



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

▢ Барилга акталж, нийслэлийн өмчийн ▢
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 7 сургуулийн хуучин барилгыг буулгаж, шинээр өргөтгөлийн барилга барих болсонтой холбогдуулан Хотын стандарт, хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 02-13-01/026/30 тоот барилгын ашиглалтын төлөв байдлын тухай дүгнэлтийг үндэслэн тус сургуулийн баланст бүртгэлтэй, нийт 186,423,325.79 (нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун хорин гурван мянга гурван зуун хорин таван төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 116,666,787.41 (нэг зуун арван зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга долоон зуун наян долоон төгрөг дөчин нэгэн мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад дурдсан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100957

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
58 дугаар тогтоолын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2023.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн хичээлийн А байр (хуучин барилга)	1972	Хан-Уул дүүрэг 16 дугаар хороо сургуулийн гудамж	186,423,325.79	70,419,538.38	116,003,787.41	Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 02-13-01/026/30 тоот дүгнэлт
НИЙТ ДҮН				186,423,325.79	70,419,538.38	116,003,787.41	